



“Билэг утга төгөлдөр судар”
“Буяны үйл” хэмээх нэгдүгээр бүлэг

The World of the Lotus Sutra

Бурхан багш Грикагүд ууланд байх үеийн явдал юм. Түүний дэргэд үй олон эрэгтэй, эмэгтэй лам хуварга болон Бодисадва, бас тэнгэр хийгээд далайд амьдардаг дагина шулмасын аймаг хуран цугласан байв. Бас их, бага улсын хаад болон хааны хүү, албат иргэдээс эхлээд худалдаачин, тариачин гээд янз бүрийн хүмүүс, хүн бусын элдэв амьтад олноор цугласан байлаа.

Цугларсан олон юун түрүүнд Шагжамунигийн хөлөнд тэргүүнээ хүргэн адис авч, гурвантаа тойрон бишрэлийг үзүүлээд, элдэв ховор цэцэг хаялан өргөлийг үйлдээд хоош ухраад завилан сууцгаав.

Тэнд цугларсан бодисадва нар нь бурханы эрдэм чадалд ихэд ойртсон, сахил санваараа чандлан сахидаг бөгөөд оюун ухаан, нирвааны өндөр түвшинд хүрсэн байв. Бас сэтгэл нь машид ариун, нэн амирлангуй тул хэрэггүй жижиг зүйлд үл автах ажээ. Гагцхүү сургаалийн замд анхаарлаа төвлөрүүлсэн байдаг бөгөөд ямар ч зүйл тохиолдсон бай аминч үзлийг үл үүсгэж, шунал, тачаалд үл баригдана.

Тэдгээр Бодисадва “Хутагтын 4 үнэн”, “12 учир шалтгааны хууль” зэрэг бурхан буддагийн айлдсан бүхий л сургаалийг өөрсдөө сахин хэрэгжүүлж, хотол олноо түгээн дэлгэрүүлдэг байв. Бас эдгээр Бодисадва ямар ч тохиолдолд

түмэн олны амьдралын багш болж, зовж шаналсан хүмүүсийг авралгүйгээр орхиж чаддаггүй ажээ. Тэр үед Дайшоогон Бодисадва бээр цугларсан хүмүүс бурхан буддагийн сургаалийг сонсохсон гэхээс тэсч ядан буйг илтэд танин мэдээд бусад олон Бодисадвагийн хамтаар суудлаасаа босч, бурхан багшид алгаа хамтатган мөргөөд, элдэв ховор зүйлээр тахил өргөв.

Улмаар Бурхан багшийн гэгээрлийг олсон замнал, түүний аугаа их асрал хайрын сэтгэл, гучин хоёр лагшин, наян найрал бүрдсэн төгс жавхланта дүр, дуу хоолойных нь уянга яруу хийгээд түүний сургаалиар хамаг амьтадын сэтгэл ариуслыг олж аврагдаж байгаад талархсанаа илэрхийлж магтан дуулдаг.

«Бурхан багш урт хугацаагаар хүнд хэцүү дияаныг үйлдэж, өөрийгөө үл хайрлан зүтгэж, ямар ч бэрх зовлонг тэсвэрлэн давж, өөрт байсан бүх зүйлээ хаясан билээ. Гагцхүү хамаг амьтадыг аврахын тухайтад өөрийгөө зориулж, билгэ билгүүний оргилд хүрсэн билээ. Улмаар тэрхүү билгэ билгүүний хүчээрээ хамаг амьтадыг гэгээрлийн замд хөтөлдөг боллоо. Тэрхүү их хичээл зүтгэл дор бишрэн мөргье.» хэмээн бурхан багшийг магтан дуулдаг.

Special Topics

“Дэлхийн Залуучуудын Удирдагчдын 2-р Их Хуралын нээлт”!!

Өнгөрөгч сарын 19-ний өдөр “Дэлхийн залуу удирдагчдын хоёрдугаар их хурал” Олон улсын төв дээр болж өнгөрлөө.

Тайланд, Шри-Ланка, Бангладеш, Энэтхэг, Канбожиа, Тайван, Солонгос, Америк зэрэг нийт 8 орноос орчуулагчын хамт 14 гишүүн ирсэн юм. Хурлаар улс орон бүрийн залуучуудын бүлгийн үйл ажиллагааны талаар танилцуулж “ОУ-ын залуу шашинтнуудын дияаны үйлийн хөгжил дэвшил” сэдвээр ярилцсан юм.

Мөн 20, 21-ний өдөр Японы “Залуу удирдагч нарын их хурал” болсон бөгөөд уг хуралд гадаадын 14 гишүүн маань оролцсон юм. Уг хурал дээр “ARMS DOWN”-ны тусгай зөвлөх, “Хавай” нийгэмлэгийн гишүүн Кристин Кёоко Сэрано гуай өөрийн туршлагаас хуваалцаж, илтгэл

тавьсан юм. Мөн ирээдүйн Ерөнхийлөгч болох Коошо багш «Энд цугларсан гишүүн тус бүр Үүсгэн Байгуулагчийн сэтгэлийн генийг уламжилж авсан» хэмээн айлдлаа. Тус хурлын дараагаар гадаад гишүүдийн төлөөлөл Коошо багштай тусгайлан уулзаж ярилцсан юм.

Дэлхийн залуу гишүүдийнхээ цаашдыг үйл ажиллагаанд амжилт хүсэхийн сацуу, их итгэл найдвар хүлээлгэсэнээ уламжилахад таатай байна.



Гэгээрэлд хүрэх

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч
Нивано Ничикоу

Амьдрах чадвараа хөгжүүлэх нь

Арван хоёрдугаа сар бол Шагжамүни буддагийн гэгээрэлийг олсон бэлиг дэмбрэлтэй сар юм. Бас ихэнх хүмүүс энэ сард өнгөрч буй нэг жилийнхээ үр дүнг эргэн харж, шинэ оныхоо зорилгыг тавьдаг.

Буддистуудын хувьд Шагжамүни буддаг амьд байх үеэс л нүглээ наминчлах ёсыг ихэд чухалчилж ирсэн. Хүнлэг ёсноос хазайж, бусдыг эмзэглүүлэх үг хэлсэн тохиолдолд хуваргуудын өмнө гарч тэр тухай илэн, далангүй илчлэн хэлж, сэтгэлээ тэгшитгэх явдал нь нүглээ наманчлах үйлийн утга учир билээ.

РКК-д гэсэн сангагийн өмнө хүний ёсноос хазайсан алдаа, эндэгдлээ ний нуугүй дэлгэн ярьдаг болсоор удаж байна. Нүглээ наманчлах үйл нь нэр төрөө хамгаалах гэсэн би төвт үзлийн хүлээсийг таслах боломж юм. Илэн далангүй ярьснаараа сэтгэл хөнгөрч, урагш тэмүүлсэн өөдрөг болж ирдэг. Бас ямар ч бэрхшээлийг даван туулах зориг, тэвчээр ундарч ирдэг.

Би нийгэмлэгт явдаг болж эхлээд, хүмүүсийн өмнө юу ярих вэ хэмээн шаналж байтал Үүсгэн байгуулагч «Өөрийн зорилго, шийдвэрийг ярьвал сайн. Бусдын өмнө ярьсан зорилгыг биелүүлэхээс өөр замгүй болдог юм» гэж зөвлөж билээ. Нүүрэндээ зүүсэн багийг тайлах гэсэн утгаар ч нүглээ наманчлах үйлийг ойлгож болох юм.

Гэвч өөрийн хийсэн гэм нүгэлд хэт баригдвал «Би ер нь хэрэггүй хүн» хэмээн өөрийгөө үгүйсгэх сэтгэл төрдөг. Бодисадва нирвааны сударт «Тэгшид суугаад үнэнийг бясалга» гэж бичсэн байдаг. Хэнд ч гэсэн хар, цагаан сэтгэл байдаг бөгөөд аль аль нь хөгжих боломжтой



байдаг. Энэ бол хүн төрөлхтний үнэн дүр дөрх юм. Нэмж хэлэхэд сайн, муу, бузар, ариун хэмээх ялгааг даван туулсан ертөнц нь энэ орчлонгийн жинхэнэ дүр төрх юм. Туйлшралд авталгүй, хүний ёсноос хазайсан сэтгэлээ тэгшитгэн засаж өөрийн сэтгэлийг сайжруулахын төлөө хичээгтүн. Энэ нь маргааштай золгох, нүглээ наманчлах үйл билээ.

Өөртөө итгэх итгэлгүй үедээ сайн талаасаа илүү муу тал дээрээ хамаг анхаарлаа төвлөрүүлчихдэг бидэнд, Доогэн хутагт ингэж сургасан байдаг. “Энэ бие ээ мунхаг хэмээн мэдвээс түүнийг нуух хэрэг юун. Мунхаг гэдгээ ухаарсан дариудаа засахын тухайтад хичээхгүй юм бол хэзээ засна гэж хичээх вэ. Хичээвээс бурхан болох нь гарцаагүй” хэмээжээ.

Гэмээ наманчлах явдал нь гэгээрэлд хүрэх замаар, зөв зүйтэй замнаж байгаа эсэхээ бататган, шалгах үйл болдог. Тиймээс өөрийн дутагдлыг анзаарсан дариудаа түүнийг шударгаар хүлээн зөвшөөрч, засаж залруулахын тулд хичээх нь зүйтэй хэмээн Доогэн хутагт сургажээ.

Талархлын сэтгэл дутсан гэдгээ анзаарвал талархаж сурахын тулд хичээ. Нинжин сэтгэлээр дулимаг гэдгээ мэдвэл түүнийг хөгжүүлэхийн тухайтад шамдах нь чухал. Ингэж чадвал тэдгээр үйл нь гэгээрлийн замаар зөв, зүйтэй замнахад туслах жинхэнэ наманчлал болох билээ.

Үүсгэн байгуулагч нүглээ наманчлах тухай «Өөрийн алдаа дутагдлыг ичиж, нуулгүй гаргаж чадвал хүн сэтгэлийн хувьд ихээхэн хөгжиж

чаддаг» гэж хэлсэн байдаг. Өөрийн дутагдлыг далдалж нуулгүй, илэн далангүй дэлгэн ярьж, наманчилбал гарт орсон өргөсийг авсан мэт сэтгэл хөнгөрч чөлөөлөгддөг. Бас өөдрөг, гэгээлэг болохын зэрэгцээ амьдрах арга зам өөрчлөгдөөд ирдэг. Өөрөөр хэлбэл гэмээ наманчилснаар амьдрал шинээр эхэлдэг юм.


Гэхдээ гэмээ наманчилж, талархлын сэтгэлээ хөгжүүлэх нь л дияаны үйл хэмээн ташаа ойлгож болохгүй. ЦЛС-г «Хамаг амьтдыг номонд хөтөлж, сэтгэлийн нисваанисаас нь ангид одуульюу» гэж бичсэн байдаг шиг бусдаар хэлүүлэлгүй, өөрөөсөө эхлэн амьдралын харгуйд төөрөлдсөн хүмүүст сайн учрал, сайн шалтгаан болж, сургаалийн гэрлийг дамжуулъя хэмээн хичээгтүн. Ганцаараа ч болохнээ олон хүнийг сургаальд хөтөлөхийн тулд үргэлж сэтгэлээ чилээн зүтгэвэл нэн сайнсан. Ийхүү хичээн зүтгэх явдал нь хичээнгүйн брамида билээ. Шагжамуни буддагийн сургаалийн дагуу амьдарч чадвал гэгээрсэн бурхан болох нь гарцаагүй. Өөрийн замнаж яваа гэгээрлийн замыг эрхэмлэн дээдэлж, хамтдаа хичээцгээе.

“Косей” 2010 оны 12 сарын дугаараас



Судар уншихад сэтгэл тайвширдаг

Оклахама нийгэмлэг
Кярол Юүар



Христос шүтлэгтэй гэр бүлд төрж өссөн болохоор бурханы шашны судар, номын тухай сонсоогүй өссөн би бээр өдгөө судар уншиж сэтгэлээ тайвшруулдаг болсон. Косей кайгийн тухай анх 2000 онд олж мэдсэн юм. Өөрийн танил Крис • Ладосо (өдгөө Хавай нийгэмлэгийн тэргүүн) -гоос шалтгаан үрийн сургаалийн талаар сонссон маань надад буддын шашинтан болох үндсийг тавьж өгсөн. Тэрээр надад “Өөрийн сэтгэл ямар байхаас шалтгаалж юмс үзэгдэл өөрчлөгдөнө” гэж хэлсэн юм. Тэр сургаалийг сонсоод тэрхүү сургаалийг дагаж амьдарвал сэтгэл хангалуун амьдарч чадах мэт санагдав. Улмаар өвөг дээдсийнхээ хойтын буяныг үйлдэх тухай заавар авч гишүүнээр элссэн юм.

Эцэг эх маань өөд болоод удаж байгаа ч, би тэд нарыгаа амьд ахуйд нь сайн харж хандаж чадаагүйдээ харамсаж явдаг байлаа. Тэднийгээ хойд төрөлдөө аз жаргалтай байгаасай хэмээн хүсэж гэртээ өвөг дээдсийн хойтын буяны ном

хуруулсан юм. Бас өөрөө өдөр бүр гэртээ судар хурж болох тухай сонсоод ихэд баярлаж билээ. Судараа олон дахин уншаад ирэхтэй зэрэгцээд унших чадвар маань нэлээд сайжирав. Улмаар уншиж буй судрынхаа утгыг нь мэдмээр санагдаад нийгэмлэгт очдог боллоо. Номын анд нар маань миний асуултанд нэг бүрчлэн гүн, нарийн тайлбарлаж өгсний ачаар би буддын үндсэн сургааль болон Цагаан Лянхуа Судрын талаар мэдлэгтэй болов.

Тэн дундаас «Бурханлаг чанар»-ын тухай сургааль сэтгэлд маань хоногшиж үлдэв. “Хүн бүр бурханлаг чанартай” гэдгийг сонсоод сэтгэл маань баяр хөөрөөр бялхаж ирсэн. Улмаар бусад хүмүүс ч гэсэн бурханлаг чанартай эрхэм, нандин оршихуй гэдгийг анзаарсан юм. Өмнө би бээр хувиа хичээсэн, бусдыг шүүмжилж, шүүдэг занатай байлаа. Гэвч сургаалийн ачаар үзэл бодол минь 180 градус өөрчлөгдсөн юм.

Судар уншихтай зэрэгцээд сэтгэл маань илүү уян хатан болж ирсэн. Хүн бүр өөрийн үзэл бодлыг дээдэлдэг Америкт төрж өссөн надад “би төвт үзэл»-ээ дарахад ихээхэн хэцүү байлаа. Гэвч ч хүмүүстэй аль болох уян хатан, нигүүлсэхүйн сэтгэлээр харьцахыг хичээдэг болсон юм.

Судараас би «Бодисадва нирвааны даяны бүтээлээс» бүлгийг унших их дуртай. Цаг ямагт хувьсан өөрчлөгдөх сэтгэлээ номхруулан жолоодож, зургаан ишээ (6 мэдэрхүй) ариусган, бага ч гэсэн хүнд тус болохыг төлөө хичээж байна. Эцэг эхдээ аз жаргалыг хүсэн хурж эхэлсэн судрын уншлага маань одоо хүмүүсийн аз жаргалын төлөө болж өөрчлөгдсөн. Одоо бол хүмүүс өвчингүй, эрүүл энх, аз жаргалтай амьдрахын тухайтад алга хавсран залбирдаг болсон.

“Якушин” Гадаад мэдээ 2009 оны 2 сарын дугаараас



Түмний зовлонг үүрсэн хүн

“Крисмасын баяр нь үнэхээр гайхалтай үзэгдэл” хэмээн Кенэс • Вүдроф гэдэг хүн хэлсэн байдаг. Яагаад гэвэл Ромын эзэнт гүрний захад амьдарч байгаад өдөөн хатгагч хэмээн цаазлагдсан нэгэн хар ажилтны хүү (Есүс христ) -ийн мэндэлсэн өдрийг дэлхий даяар тэмдгэлдэг учраас хэмээн хэлсэн байдаг. Үүнийг сонсоод нээрээ л тийм дээ гэж бодогдов. Цорын ганц хүн дэлхийн бүх хүмүүст нөлөөлж, дэлхийн түүхийг өөрчилж ирсэн. Тэр нэг хүмүүний хүч чадал чухам юунд оршдог юм бол. Тэр бол Есүс христээс хүмүүс, хүн төрөлхтний хүсэж мөрөөдөж ирсэн дүр төрхийг олж харсан болохоор гэж бодогдоно. Түмний довлонг нуруундаа үүрч, тэдний өмнөөс шийтгэл хүлээн, загалмайд цовдлогдсон түүнийг хараад хүмүүс «Би ч гэсэн түүн шиг үнэний замыг туулахсан» хэмээн хүсэж. Түүний амьдралын замналыг хамгийн үнэн зам хэмээн хүлээн зөвшөөрч, тэр замаар замная хэмээн сэтгэл шулуудсанд оршдог болов уу. Өөрөөр хэлбэл Есүс христэд хүмүүсийн хүсэж тэмүүлдэг дүр төрх цогцолсон байсан гэж хэлж болно. Өөрийн биеэр хүмүүст хайрын тухай заасан түүний гайхамшигт түүх мөнхөд хүн төрөлхтнийг дагаж ирсэн нь энэ болов уу.

“Үүсгэн Байгуулагчийн үг” 4-94-95х

Information
Dec. 2010

SHAN-ZAI-сэтгүүл нь та бүхний санал сэтгэгдэлийг хүлээж авсаар байгаа. “Сонирхсон сэдэв”, “Буддизмын талаар мэдмээр байгаа зүйл”, “Сэтгэл зовоосон асуудал” байгаа бол бидэнд хандаарай. Бид та бүхний саналыг талархан хүлээж авна. Харилцах хаягийг энэ хуудасны доод булангаас харна уу.

С О Л У М Н


Та бүхэн энхүү бяцхан зурвасыг минь унших үед Японд аль хэдийнэ өвөл болсон байгаа. Гэвч яг одоо энд намрын сүүлийн налгар өдрүүд үргэлжилж байна. Зуны халуун өдрүүд улирч намрын сэрүү орсон болоод ч тэрүү модод шаргалтаад үнэхээр үзэсгэлэнтэй. Сакура цэцгийн модны навчис улаан өнгөөр өмсгөлөө сольжээ. Нарны шаргал туяанд өнгө өнгөөр гялтганах навчисыг хараад зүйрлэн хэлэх зүйл үл олдоно. Гэвч байглын энэхүү үзэсгэлэнг мэдэрч бишрэн дуулдаг нь гагцхүү хүмүүс бид биш гэж үү. Тэгвэл үзэсгэлэнтэй зүйлийг хараад үзэсгэлэнтэй хэмээн мэдэрч чаддаг гайхалтай чадварыг заяасан бурхан буддад сэтгэлийнхээ угаас талархмаар.

Косей Кай 12 сараас шинэ онтойгоо золгоно. Орчлонгийн он тооллоос нэг сарын өмнө шүү дээ. Яагаад гэвэл оны сүүлд тайван хүмүүс ч сандарч мэгдэхээр завгүй болдог. Тиймээс Үүсгэн Байгуулагч маань зав гаргахын тулд 11 сарыг оны эцсийн сар хэмээн тооцдог болсон юм. Тийм болохоор энэ сарыг улирлын сайхныг мэдэрч өөдрөг сэтгэлээр үдэцгээе.

(Kotaro Suzuki)

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван сузар”-ыг цомлолынхоо эх үүсвэр болгож, тэр бүлээрээ шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



SHAN-ZAI 2010 он 12 сар (Vol.63)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв. Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan, TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224, E-mail : shanzai@kosei-kai.or.jp
Ерөнхий редактор: Хагивара Туслах редактор: Ms. Etsuko NAKAMURA Ажилчид: Шихо-Мацуока, Юүкино-Күдо, Каори-Сайто, Маюүми-Это, Саюүри-Сүзүки, Эрико-Кано, Макино-Эми

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2011

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@buddhistcenter-rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.rkina.org/tampabay

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@mail.rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: bonnerstyle@sbcglobal.net

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N San Mateo Dr, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami3370@hotmail.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

4340 E Kentucky Ave #345 Glendale CO 80234, U.S.A.
Tel: 1-303-319-2765 Fax: 1-720-876-4534

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: hiromi_mat@yahoo.com http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, the Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 Fax: 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**Rissho Kosei-kai of Singapore****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibt-rk.org/

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 Fax: 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

"Suwisal" Bataganwila, Imaduwa, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 Fax: 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 Fax: 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

114, Nanshi Si Road, Zenruzhen, Putuo-qu, Shanghai, China